



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 113

Мандалговь

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ээлжит хоёрдугаар хуралдааны тов зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хоёрдугаар хуралдааныг 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 11.00 цагаас Мандалговь хотод хуралдуулсугай.

Хоёр. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой санал шийдвэрийн төсөл боловсруулан ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож), аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар МН

Мандалговь

Г

Аймгийн сонгуулийн хороог
татан буулгах тухай

Г

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

Нэг. Аймаг, сумын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулсан аймгийн сонгуулийн хороог 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс татан буулгасугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ